

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 4 дүгээр сарын 27

Дугаар

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, лобби төв, хурлын танхимд эхэлж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга Ш.Энхтөр даргалав.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: 2019 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн ТУЗ-ийн хурлын 03 тогтоолын дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж байна. ХЭХ-ын Тооллогын комиссын дарга Б.Батбаяр хуралд оролцогчдын ирцийн талаар танилцуулна.

Б.БАТБАЯР/ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА/: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 6 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн байна. Хурлын ирцийг 12.30 цагийн байдлаар гаргав. Итгэмжлэл болон саналын хуудсаар хуралд оролцогч байхгүй. Хуралд оролцогчдын нийт хувьцааны тоо 462,484 ширхэг буюу компанийн нийт хувьцааны 75.25% байна.

Ирцийн тогтоол уншиж танилцуулав.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц Компаний тухай хуулийн 69.1-д заасан шаардлагыг хангаж байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг эхлүүлж, тус хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг баталж, хувьцаа эзэмшигчдээ хурлын зар, хэлэлцэх асуудлын талаар тодорхой танилцуулга, мэдээллийг хүргүүлэн ажилласан билээ. Та бүгд хурлын материалын Хурлын Дэг хэсгийг харна уу.

Дэгийн дагуу хурлаа эхлүүлье.

Хуралд оролцогчид дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: КОМПАНИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Б.ТҮВШИНТӨР /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/

Та бүгдэд дүгнэлтийг уншиж танилцуулъя:

ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт нь Компанийн тухай хууль болон "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн дүрмийн хүрээнд дүгнэгдэв.

Компани 2017, 2018 онуудад эргэлтийн хөрөнгийн дутагдалтай байдлаас болж түүхий эд худалдан авч чадаагүй бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан. Арилжааны банкны олгодог эргэлтийн хөрөнгийн зээл нь хугацаа богино, хүү өндөртэй байгаа нь зах зээлд өөрийн байр сууриа гүйцэд эзэлж чадаагүй, борлуулалт жигдрээгүй манай компанийн хувьд хүндрэлтэй байна.

Гурилын үйлдвэрт орчин үеийн бүрэн автомат тоног төхөөрөмжийг АНУ, Итали, ХБНГУ, БНТУ, ОХУ-аас авахад 5,9 тэрбум төгрөг зарцуулж, 2016- 2017 онд туршилт тохируулга хийн гурил үйлдвэрлэж 5,1 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ.

эргэлтийн хөрөнгийн зээл нь хугацаа богино, хүү өндөртэй байгаа нь зах зээлд өөрийн байр сууриа гүйцэд эзэлж чадаагүй, борлуулалт жигдрээгүй манай компанийн хувьд хүндрэлтэй байна.

Гурилын үйлдвэрт орчин үеийн бүрэн автомат тоног төхөөрөмжийг АНУ, Итали, ХБНГУ, БНТУ, ОХУ-аас авахад 5,9 тэрбум төгрөг зарцуулж, 2016- 2017 онд туршилт тохируулга хийн гурил үйлдвэрлэж 5,1 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ.

"Од бүртгэл аудит" ХХК-аар 2017, 2018 онуудын санхүүгийн тайланд аудит хийлгэсний үрээр тайланд тусгагдсан давхардсан бичилтүүдийг задлан залруулах бичилт, өглөг, авлагын бүртгэлийг нэг бүрчлэн тулган баталгаажуулж, хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан, нас барсан иргэн, татан буугдсан хуулийн этгээдийн жагсаалт гарган бүртгэлээс хасаж, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх 16,8 тэрбум, ангиллын 13,3 тэрбум төгрөгийн залруулга хийсэн. Түүнчлэн "Атен" ХХК-иар компанийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэснээр давхар бүртгэгдсэн болон устаж үгүй болсон хасагдах хөрөнгүүдийг хасаж, улсын бүртгэлд бүртгэгдээгүй байсан хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг бүртгэлжүүлж гэрчилгээжүүлсэн. Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Үнэлгээний Олон улсын стандартын дагуу компанийн хөрөнгийн бодит үнэ цэнийг 40,5 тэрбум төгрөг гэж тогтоолоо.

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-ийн хурлаар батлагдсан дүрмийн хүрээнд компанийн засаглалыг сайжруулах, гүйцэтгэх удирдлагын багийг шинээр томилох, хувьцаа нэмж гаргах замаар эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн санхүүжилтийг бий болгохоор ажиллаж байна.

Бизнес төлөвлөгөөнд гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэмэлт шугам угсрах бэлтгэлийг хангах, нэрийн бүтээгдэхүүний төрлийг нэмж эцсийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх, гурилыг баяжуулах, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант жилд "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөгөөний дагуу бүхий л боломжоороо ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Дүгнэлтийг бүгд сонслоо. Санал, асуулт байна уу. За, асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал руу орёё.

Хуралд оролцогчид дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ХУВЬЦАА ХУВААХ ТӨСӨЛ

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Б.ТҮВШИНТӨР /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/

Энэ асуудлыг хэлэлцэхээс өмнө та бүгдэд хэлэлцэх гэж буй асуудалтай холбоотой нэмэлт мэдээлэл өгье. Бид МХБ болон СЗХ -нд хүргүүлж, олон нийтэд зарласан хурлын зар буюу та бүгдэд тараагдсан хурлын материалд дурьдсанчлан дараах 6 асуудлыг хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Хувьцаа хуваах төслийг батлах тухай;
3. Хувьцаа нэмж гаргах тухай, хувьцаа нэмж гаргах төслийг батлах тухай ;
4. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авахыг эрхийг эдлүүлэх эсэх тухай;
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
6. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан ТУЗ-н шийдвэрийг танилцуулах;

Эдгээр зургаан асуудлын 1-5 р асуудлаар ХЭХ-с шийдвэр гаргахаар тогтоолын төсөл төлөвлөсөн байсан болно. Гэвч тогтоолын төсөл төлөвлөх явцад хуулийн компаниас зөвлөгөө авахад 2 болон 5-р асуудлууд нь нэг асуудлаар давхардсан тогтоол төлөвлөсөн

байна гэж зөвлөсөн болно. Иймд бид уг хоёр асуудлыг нэгтгэж, ХЭХ-с гарах нэг тогтоолын төсөл төлөвлөсөн болно. Ийнхүү нэгтгэсэн тогтоол гарсанаар эцсийн үр дүнд өөрчлөлт орохгүй юм. Та бүгдэд тараагдсан санал авах хуудсанд 4 асуудлаар санал авахаар болсон байгаа нь ийм учиртай болно. Ер нь 2019 оны 3 сарын 15-ны өдрийн ТУЗ-н хурал дээр хувьцаа хуваахтай холбоотой заавал дүрэмд өөрчлөлт орно, иймд “компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай” гэж санал авах асуудал оруулья гэж ярилцсан бөгөөд энэ талаар ч тухайн өдрийн ТУЗ хурлын тэмдэглэлд тодорхой бичигдсэн, тэрхүү тэмдэглэлийг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн байгаа болно.

Харин одоо үндсэн хэлэлцэх асуудалдаа орьё. Хувьцаа хуваах төслийг танилцуулья.

Их болон бага хувьчлалын үед хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн хувьцаат компаниудын гаргасан хувьцааны тоо ширхэг цөөн, төвлөрөл өндөр байдаг зэрэг нь хоёрдогч зах зээлийн эргэлт үүсэхгүй байх, хувьцааны хөрвөх чадвар муу байхад шууд нөлөөлж байна. Энэ хүчин зүйл нь МХБ-д бүртгэлтэй олон хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээ нь бодит бизнесийн үнэ цэнийн тусгал болж чадахгүй байхад нөлөөлж байна.

"Дархан Гурил Тэжээл" хувьцаат компани нь өнөөгийн байдлаар 1200 орчим хувьцаа эзэмшигчдтэй бөгөөд үүний дотор 100 ширхэгээс бага хувьцааг эзэмшигчид дийлэнх хувийг эзлэж байна.

Компанийн үнэт цаасны арилжаа бараг явагддаггүй бөгөөд өнгөрсөн 3 жилийн хугацаанд 25 удаа л компанийн хувьцааны арилжаа Монголын хөрөнгийн биржээр явагдсан байна.

Иймд "Дархан Гурил Тэжээл" ХК нь нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө босгож, зогсолтод ороод байсан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сэргээх, нөгөө талаас голлох хувьцаа эзэмшигчдийн хувьцааны төвлөрөлийг бууруулж, олон нийтийн хувь эзэмшлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Нэмж хувьцаа гаргах болон хувьцаа хуваах асуудлууд нь салшгүй уялдаа холбоотой, зэрэг хэрэгжих шаардлагатай үйл явц юм. Хэрвээ хуваахгүйгээр нэмж хувьцаа гаргах тохиолдолд нэгж хувьцааны үнэ ханш нь ихээхэн өндөр үнээр тогтох¹ бөгөөд энэ нь нэмж хувьцаа гаргасны дараах хөрвөх чадварт сөрөг үр дагавартай юм. Иймд бид хувьцаа хуваах, хувьцаа нэмж гаргах асуудлыг нэгэн зэрэг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэхээр төлөвлөвөг байна.

Хувьцаа хувааснаар дараах ач холбогдолтой. Үүнд

- Нэгж хувьцааны үнэ хямд болсноор хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэнэ.
- Хувьцааны арилжааны идэвхи нэмэгдэж, хөрвөх чадвар сайжирна.
- Эрэлт нийлүүлэлт нэмэгдсэнээр, хувьцааны ханш бодитой тогтох боломж бүрдэнэ.

Үндэслэл

"Компанийн тухай хууль"-ийн 51.3-т "Компани нь нэг хувьцааг тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцаагаа хувааж болно" гэж заасны дагуу компани нь нэгж хувьцааг 1,000 ширхэгт хуваахаар төлөвлөж байна.

Хувьцаа хувааснаар арилжаа идэвхжиж, хөрөнгийн биржийн арилжаанд орсон өдрийн тоонд эерэг өөрчлөлт үүсдэгийг "АПУ" ХК, "СҮҮ" ХК болон "Хөвсгөл Алтандуулга" ХК –н жишээг үзүүлсэн дараах хүснэгтээс тодорхой харж болохоор байна.

Компанийн нэр	Тухайн 1 жилд арилжаанд орсон өдөр	Өөрчлөлтийн хувь

¹ Компанийн тухай хуулийн 32.5 -Хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр гаргахыг хориглоно.

СҮҮ ХК	Хуваахаас өмнө	87	↑ 160%
	Хуваасны дараа	227	
АПУ ХК	Хуваахаас өмнө	154	↑ 48%
	Хуваасны дараа	228	
"Хөвсгөл Алтандуулга" ХК	Хуваахаас өмнө	15	↑ 706%
	Хуваасны дараа	121	

Хувьцаа хуваах тооцоолол

Одоо бүртгэлтэй байгаа компанийн зарласан бөгөөд гаргасан 614,603 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,000 ширхэг болгон хувааж 614,603,000 ширхэг хувьцаатай болж, бутархай үлдэгдэл үлдэхгүй болно.

	Хувьцаа хуваахын өмнө	Хувьцаа хуваах нөхцөл	Хувьцаа хуваасны дараа
Нийт хувьцааны тоо	614'603	1=1000	614,603,000
Хувьцааны нэрлэсэн үнэ	100 төгрөг	1/1000	10 мөнгө

Хувьцаа хуваахтай холбоотой үүссэн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх

Компанийн хувьцааг хуваах үйл ажиллагааг хэрэгжүүлж буйтай холбогдон хувьцаа эзэмшигчдийн эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй бөгөөд компанийн зүгээс авч хэрэгжүүлэх ямар нэгэн ажиллагаа шинэ үүрэг үүсэхгүй.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Хувьцаа хуваах төслийг бүгд сонслоо. Санал, асуулт байна уу. За, асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал руу орьё.

Хуралд оролцогчид дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ ТӨСӨЛ

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Б.ТҮВШИНТӨР /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/

Та бүгдэд хувьцаа нэмж гаргах төслийг уншиж танилцуулья:

1. Төслийн зорилго:

- 1.1 "Дархан Гурил Тэжээл" ХК -ийн гурилын үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээмж, үр ашгийг сайжруулах, зорилтот зах зээл дэх байр суурийг нэмэгдүүлэхээр Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа нэмж гаргах шийдвэр гаргах, түүнтэй холбогдоотойгоор үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Төсөл хэрэгжүүлэгч буюу үнэт цаас гаргагчийн нэр: "Дархан Гурил Тэжээл" ХК
- 1.3 Үнэт цаас гаргагчийн хаяг: Дархан Уул аймаг, Дархан сум, 1-р баг
- 1.4 Компанийн тухай хуулийн 62.1.3-д заасны дагуу "Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн, компанийн тухай хуулийн 63.7-д "Энэ хуулийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй

хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд нэмж хувьцаа гаргах төслийг танилцуулж байна.

2. Төслийн ач холбогдол:

- 2.1 Гурил тэжээлийн үйлдвэр: Гурил тэжээлийн үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаар ажиллан, түүхий эдийн тогтвортой нөөцтэй болж, зорилтот зах зээлийн хэрэгцээг найдвартай хангах, бүтээгдэхүүний нэр төрөл олшрух
- 2.2 Экспорт хийх: Гурил болон гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспорт хийх
- 2.3 Санхүү: Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх

3. Компанийн эрхэм зорилго, компанийн танилцуулга, үйл ажиллагааны тухай

Компанийн 2019-2024 оны үндсэн зорилтууд

Гурил тэжээлийн үйлдвэрлэлийг тасалдалгүй, тогтвортой нэмэгдүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, дотоод болон гадаад зах зээлд чанартай бүтээгдэхүүн тогтвортой нийлүүлж, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд төслийн зорилго оршино.

Төлөвлөгөөг 3 үе шаттай хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат: 2019-2020 онд үйлдвэрийн үйл ажиллагааг тогтворжуулж, маркетингийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэн ердийн болон баяжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээл, худалдан авалтын тогтвортой суурийг бий болгоход анхаарч ажиллана. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагчдын хөрөнгийг компанийн үндсэн үйл ажиллагаа болох гурилын үйлдвэрээ хөгжүүлэх, зах зээлд өөрийн бүтээгдэхүүний орон зайг тэлэх, бат тогтвортой суурийг бүрдүүлэх зорилтыг энэхүү 1 дүгээр үе шатад хэрэгжүүлнэ. Мөн бүтээгдэхүүн экспорт хийх боломжийг судлана.

2 дугаар үе шат: 2021-2022 онд үйлдвэрийн үйл ажиллагаа тогтворжиж, шинээр сайн чанарын гурилыг ашиглан өндөр чанартай, монгол хүний биед нэн шаардлагатай элемент бүхий гоймон үйлдвэрлэх үйлдвэрийг шинээр ашиглалтанд оруулна.

3 дугаар үе шат: 2023-2024 онд үйлдвэрлэлийн бааз суурийг өргөжүүлж, ашиг орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр шинээр мал, амьтны тэжээлийн үйлдвэр ашиглалтанд оруулснаар гурил үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийг өндөр ашигтайгаар хаягдалгүй, бүрэн ашиглаж эцсийг бүтээгдэхүүн болгон нийлүүлсэнээр ашиг орлого нэмэгдэнэ.

Компанийн танилцуулга, үйл ажиллагаа

“Дархан Гурил Тэжээл” ХК нь бизнес төлөвлөгөөгөөр тавьж буй зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг бааз суурь, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, дэд бүтцийн хангалттай нөөцтэй болно. Турк улсын Алапала брэндийн 2014 онд үйлдвэрлэгдэн 2015-2016 онд суурилуулсан хоногт 150 тн улаанбуудай тээрэмдэх хүчин чадал бүхий бүрэн автомат гурил, тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй

- 2000 тн багтаамжтай бэлэн /гурилын/ бүтээгдэхүүний агуулах
- 1000 тн багтаамжтай бэлэн /тэжээлийн/ бүтээгдэхүүний агуулах
- 26000 тонн улаанбуудай хадгалах зориулалттай төмөр бетон агуулах
- Авто болон төмөр замын хэсгээс улаанбуудай буулгах, ачих механикжсан байгууламж
- Компаний эзэмшлийн 900 метр урттай төмөр замын хоёр салаа зам.

Монгол хүний хоол хүнсний хэрэглээнд гурил, гурилан бүтээгдэхүүн томоохон байр суурь эзэлдэг бөгөөд улаанбуудайн гурилыг стратегийн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтаан үздэг.

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй яамны статистик мэдээгээр **2016 онд** 209.7 мян.тн гурил, 38.6 мян.тн гурилан бүтээгдэхүүн, 4050.5 тн гоймон, **2017 онд** 208.7 мян.тн гурил, 43.5 мян.тн гурилан бүтээгдэхүүн, **2018 оны байдлаар** 214.9 мян.тн гурил, 7000.8 тн гоймон хэрэглэж байна. /Эх сурвалж: Хүнс, Хөдөө, Аж Ахуйн яам/

Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь хүн амын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нэг бөгөөд сүүлийн жилүүдэд гурилын бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байна.

Монгол улсын гурилын жилийн нийт хэрэгцээ 270.9 мян. тн /2016 онд жишсэн хүн амын тоонд үндэслэв/ бөгөөд үүний 43%-ийг Улаанбаатар хотын зах зээл, 57%-ийг орон нутгийн зах зээл эзэлдэг. Улсын хэмжээнд жилийн нийт хэрэгцээт гурилын 60%-80%-ийг дотоодын үйлдвэрээс 20%-40%-ийг импортоор хангаж байна.

Импортын гурилын 90% орчмыг Оросын Холбооны Улсаас хангадаг. Улсын хэмжээнд үйлдвэрлэж буй нийт гурилын 60%-70%-ийг нэгдүгээр гурил, 20%-30%-ийг дээд гурил, 10% орчмыг хоёрдугаар гурил эзлэж байна. Нийт 63 компани гурил үйлдвэрлэж буй гэсэн мэдээлэл байгаа бөгөөд суурилагдсан хүчин чадал болон үйлдвэрлэлээрээ Алтан тариа, Улаанбаатар гурил, Од групп, Милл Хаус, Өег гурил, Өгөөж чанар, Дорнод Гурил зэрэг компанийн гурилын үйлдвэрүүд /хоногт 100тн-300тн/ тэргүүлдэг. Гурилын үйлдвэрүүд нь жилд нийт 1700 орчим мянган тонн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай юм.

Хүснэгт: Гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээ

Үзүүлэлт	Огноо				
	2014	2015	2016	2017	2018
Хүн амын хэрэгцээ /мян.тн/	258.7	263.3	267.4	270.9	275.3
Дотоодын үйлдвэрлэл /мян.тн/	228.3	206.5	209.7	208.5	214.9
Гурилын импорт /мян.тн/	17.5	20.5	30.0	хийгдээгүй	9.4

Эх сурвалж: /Үндэсний статистикийн хороо, Гаалийн Ерөнхий газар/

Дээрх дүнгээс үзвэл гурилын дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол өсч, гурилын импорт буурсан, зарим жил импорт хийгдээгүй дүн харагдаж байна. Өөрөөр хэлбэл гурилын үйлдвэрлэлийн хэмжээ 2018 онд өмнөх оныхоос 6.4%, хүн амын гурилын хэрэгцээ 4% орчим өсөлттэй байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар баримтлах бодлого

- Хүнсний тухай хууль,
- Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль,
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль,
- Баяжуулсан хүнсний тухай хууль,
- Засгийн газраас 2018 оны 336 дугаар тогтоолоор батласан албан журмын баяжуулах хүнсний жагсаалтад буудайн /БГ-075, БГ-085, БГ-05/ гурил багтсан байна. Энэ ажлыг хэрэгжүүлэхээр Засгийн газраас албан журмаар баяжуулах хүнсний төрөл тус бүрээр бүтээгдэхүүний стандартыг боловсруулж 2019 оны 2 дугаар улиралд багтаан батлуулах, буудайн гурилыг баяжуулах бэлтгэл ажлыг үе шаттай зохион байгуулах асуудлыг Эрүүл мэндийн болон Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарт даалган ажиллаж байна.
- "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг 2015 онд УИХ-аар баталсан бөгөөд энэхүү бодлогод 2015-2025 онд Хөдөө аж ахуйн эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйг байгалийн аливаа эрсдлээс хамгаалах үйл ажиллагаанд баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан байна. Улсын Их Хурлын энэхүү энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2016 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат /2016-2020 он/-ны төлөвлөгөө" батлагдсан.

Эдгээр бодлогын баримт бичгүүдэд манай бизнес төслийг хэрэгжүүлэхэд таатай нөлөөлөх зарим зориулалтыг дурьдвал:

-Монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн болох гурилыг стратегийн хүнс гэж үзэх, хүнсний хангамж тогтвортой, хүртээмжтэй, хүний эрүүл мэндэд шаардлагатай шим тэжээлтэй байх

-Хүрээлэн байгаа орчин, одоо болон ирээдүй хойч үеийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалах, бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалахад чиглэсэн хариуцлагатай арга технологиор үйлдвэрлэл эрхлэх, орцын 90% болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай хүнс, тэжээл, бордоог органикт тооцох, үүнтэй холбогуулан зохих урамшуулал дэмжлэгийг төрөөс үзүүлэх

-Хүн амын амин дэм, эрдэс бодисын дутагдлаас сэргийлэх, баяжуулсан хүнсний ач холбогдлыг иргэдэд таниулах, сурталчилах ажлыг төрөөс зохион байгуулах, Хүнс үйлдвэрлэгч нь хүнс, баяжуулах зориулалтын тоног төхөөрөмжтэй байх /Уг төхөөрөмж нь манай компанид суурилуулагдсан байгаа нь бидний давуу тал болж байна./

-Эрчимжсэн мал аж ахуйг олон төрлийн тэжээлээр хангах, уургийн өндөр агууламжтай сорт, үрийн нөөц бүрдүүлэх

-Эрүүл аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд, хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах

-Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд туршиж, нэвтрүүлэх

-Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж хөгжүүлэх зэрэг.

Бидний боловсруулсан бизнес төлөвлөгөө нь бүхэлдээ төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод нийцсэн дээрх бодлогын зорилтуудын хэрэгжилтийг дэмжсэн байдлаар боловсруулагдлаа.

Үндсэндээ Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил, түүний талаар төрөөс баримталж буй бодлого нь энэхүү бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэн таатай нөлөө үзүүлэхээр байна.

Үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх стратеги

Гурилын үйлдвэрлэлийн үндсэн зорилтуудыг хангах талаар авах цогц арга хэмжээ:

- Гурилын үйлдвэрт олон улсын ISO 9001, ISO 22000 стандартуудыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, хяналт, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулж, үйлдвэрийн хүчин чадлыг 90% хүртэл ашиглана.
- Бүтээгдэхүүний нэр төрөл, ашиг орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ эцсийн бүтээгдэхүүн гоймон үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулж, шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлнэ.
- Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд анхаарахын зэрэгцээ гурилын үйлдвэрлэлд баяжуулсан гурил үйлдвэрлэх технологийг боловсруулж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл явуулах, борлуулалтыг сайжруулах чиглэлээр олон улсын болон дотоодын мэргэшсэн зөвлөх багуудтай хамтын ажиллагаагаа идэвхижүүлнэ.
- Дархан Гурил Тэжээл брэндийн органик бүтээгдэхүүний тэмдэг авах бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийнэ.

Компанийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн цаашдын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийн тухайд:

- Түүхий эд худалдан авахад шаардлагатай эргэлтийн хөрөнгө
- Үйл ажиллагааны санхүүжилт,
- Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон автомашин авах зэрэг төлөвлөгөөний 1-р үе шатыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд тус санхүүжилтыг 100 хувь нэмж хувьцаа гаргах замаар, санхүүжүүлэхээр төлөвлөөд байна. Харин 2 болон 3-р үе шатны төлөвлөгөөг компани үйл ажиллагаанаас олсон ашиг болон зээлийн шугам зэрэг бусад санхүүжилтийн хэрэгсэлээр дамжуулан санхүүжүүлэхээр төлөвлөв.

4. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

2018 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн тархалтын судалгаагаар "Дархан Гурил Тэжээл" ХК нь нийт 1267 хувьцаа эзэмшигчтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч² нь Д.Балдан-Очир, С.Намсрайжав, Б.Түвшинтөр, Б.Түвшинжаргал, Г.Баярт болон Ш.Энхтөр нар юм.

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо,	Хувьцааны тоо,	Хувьцаа хувааж, Нэмж хувьцаа гаргасны дараах байдлаар /төсөөлөл/
	хувь эзэмшил /хувьцаа хуваахын өмнөх байдлаар/	хувь эзэмшил /хувьцаа хуваасны дараах байдлаар/	
Догсомжав Балдан-Очир	119,775 ширхэг 19.49%	119,775,000 ширхэг 19.49%	15.81%

² Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29- "нөлөө бүхий хувьцаа эзэмшигч" гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

Сосорбарам Намсрайжав	120,109 ширхэг 19.54%	120,109,000 ширхэг 19.54%	15.86%
Балдан-Очир Түвшинтөр	30,928 ширхэг 5.03%	30,928,000 ширхэг 5.03%	4.08%
Балдан-Очир Түвшинжаргал	159,631 ширхэг 25.97%	159,631,000 ширхэг 25.97%	21.07%
Гэндэнсүрэн Баярт	90,302 ширхэг 14.69%	90,302,000 ширхэг 14.69%	11.92%
Шаравсамбуу Энхтөр	30,740 ширхэг 5.00%	30,740,000 ширхэг 5.00%	4.06%
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид	89,73%	89,73%	72.81%
Бусад хувьцаа эзэмшигчид	10.27%	10.27%	27.19%
Нийт	100.00%	100.00%	100.00%

5. Нэмж гаргах хувьцааны талаар

5.1. "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн 2019 оны 3 дугаар сарын 15-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2019 оны 4 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа нэмж гаргах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

"Дархан Гурил Тэжээл" ХК нь компанийн тухай хуулийн 51.3-д "Компани нь нэг хувьцааг тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцаагаа хувааж болно" гэж заасны дагуу компанийн энгийн хувьцааг хувааж, өөрчлөлт оруулахаар 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн бөгөөд уг асуудлын дагуу төсөл боловсруулан 2019 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэгэн зэрэг хэлэлцэхээр бэлтгээд байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар компанийн нэгж хувьцааг 1000 хуваах асуудлыг зөвшөөрсөн тохиолдолд, МХБ-д бүртгэлтэй 1 (Нэг) хувьцааг 1000 (Нэг мянга) ширхэг хувьцаанд хөрвүүлэх замаар хувааж, компани нэг бүр нь 10 мөнгөний хэрлэсэн үнэ бүрий нийт 614,603,000 ширхэг энгийн хувьцаатай болно. Хувьцаа хуваах, нэмж үнэт цаас гаргах төсөл, үүнтэй холбоотой компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг Монголын Хөрөнгийн Биржид нэгэн зэрэг хүргүүлэх юм. Монголын Хөрөнгийн Бирж хувьцаа хуваах, нэмж хувьцаа гаргах буюу үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг хянаж, МХБ-ийн бүртгэлийн шийдвэр гарсны дараа СЗХ-д хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлнэ. СЗХ-ноос "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн хувьцаа хуваах, нэмж гаргах хувьцааг бүртгэснээр, компанийн хувьцаа хуваагдана. Мөн нэмэлт хувьцаа гаргах ажиллагаа хэрэгжиж эхэлнэ.

5.2 Нэмж гаргах хувьцааны талаар:

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн энгийн хувьцаа	Тоо ширхэг		Тоо ширхэг	
	Хувь <i>/Хувьцаа хуваахын өмнөх байдлаар/</i>		Хувь <i>/Хувьцаа хуваасны дараах байдлаар/</i>	
Гаргасан буюу эргэлтэнд байгаа хувьцааны тоо:	614,603	81.14%	614,603,000	81.14%
Нэмж гаргах хувьцаа	142,845	18.86%	142,845,000	18.86%
Хувьцаа нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	757,448	100.00%	757,448,000	100.00%

5.3 Нэмж гаргах хувьцааны үнийн мэдээлэл:

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн нэмж гаргах хувьцааны үнийг компанийн тухай хуулийн 55.2, 76.1.6-д заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлд нэмж гаргаж буй хувьцааны үнэ, түүнтэй холбоотой шийдвэр гаргах эрхийг олгохоор хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөлд тусгаад байна.

6. "Дархан Гурил Тэжээл" ХК нэмж хувьцаа гаргах шийдвэртэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх тухай

6.1.Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй тухай

Хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар ТУЗ-өөс саналыг оруулж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, уг асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.2 Компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх.

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд, нээлттэй хүрээнд гаргах шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.2, 87 дугаар зүйлийн 87.1.1 болон 87.1.2, 88 дугаар зүйлийн 88.3-д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг **шаардах эрх үүсэхгүй**. Шинээр нэмж гаргах хувьцааны тоо нь компанийн урьд гаргасан хувьцааны 25%-д хүрэхгүй тул их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй болно.

7. Компани нэмж хувьцаа гаргах ажиллагааг дуусгавар болгох

7.1.Компанийн ТУЗ, андеррайтер болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хувьцаа эзэмшигчдээс олгогдсон эрхийн дагуу нэмж хувьцаа гаргах ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

7.2.Компанийн нэмж хувьцаа гаргах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталснаар Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд нэмж гаргаж буй хувьцааг бүртгүүлэх, нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд, нээлттэй хүрээнд санал болгон арилжаалж, шаардлагатай санхүүжилтыг татах ажиллагааг дуусах хүртэл бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.3.Санхүүгийн зохицуулах хорооноос нэмж хувьцаа гаргахыг зөвшөөрсөн шийдвэр гарсан өдрөөс эхлэн нэмэлт хувьцаагаа олон нийтэд сурталчлах, хувьцааг МХБ-ээр арилжаалж, компани нэмж хувьцаа гарган шаардлагатай санхүүжилтыг татан төвлөрүүлж, хувьцааны арилжааны тайланг холбогдох байгууллагуудад гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлснээр нэмж хувьцаа гаргах үйл ажиллагаа дуусгавар болно.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Маш дэлгэрэнгүй уншиж танилцуулж өгсөн Гүйцэтгэх Захиралд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс уг төсөлтэй холбоотой асуух асуулт болон санал байна уу.

Д.БАЛДАН-ОЧИР /ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ/: Өнөөдөр нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс гадна 1 шинэ хувьцаа эзэмшигч ирсэн байна. Тийм учраас компанийн тухай түүхэн мэдээлэл өгмөөр санагдлаа. Манай Дархан Гурил Тэжээллийн үйлдвэр нь анх биднийг хувьцаа эзэмшигч болон ирж байх үед маш хуучирсан, хоцрогдсон тоног төхөөрөмжтэй, шилжилтийн нийгмийн цалгар цаг үед ихээхэн тоногдсон байдалтай байсан. Бид ийм л үйлдвэр хүлээж авсан. Тоногдсон, хуучирсан, хүндрэлд орсон байхад нь авсан.

Бид олон жил энэхүү хүндрэл бэрхшээлээс нь гаргахаар бүхий л боломж, бүр тодорхой хэлбэл, өөрийн хувийн нөөц боломжийг хүртэл дайчилсаар өнөөдрийг хүрлээ. Маш олон саад тотгор, давааг давж ирсэн. Бид ямартай ч үйлдвэртээ тоног төхөөрөмжийн бүрэн шинэчлэл хийж чадсан бөгөөд мөн түүнээс хойш тодорхой хэмжээний үйлдвэрлэл явуулж, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулсан.

Гэвч бид банк санхүүгийн байгууллагад өр, төлбөр ихтэй байсаар байна. Үйлдвэрлэлээ сэргээх, санхүүгийн хүндрэлээс гарах үүднээс өнгөрсөн оноос нээлттэй бонд гаргах талаар судалж эхэлсэн. Гэвч одоогийн санхүүгийн хүндрэлтэй байгаа дээр нэмж өндөртэй хүүтэй эх үүсвэр татах нь бүр хүнд дарамтанд оруулна гэж үзээд бонд гаргах асуудлаа зогсоосон. Харин нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгийн харьцааг сайжруулж, эргэлтийн хөрөнгөтэй болох нь зүйтэй гэж үзээд өнөөдөр энэ асуудлыг хэлэлцэж байна. Цаашид компани нь үйлдвэрлэлээ сэргээж, хуучин болон шинээр орж ирэх нийт хувьцаа эзэмшигчдэд өгөөжөө өгдөг, засаглал болон тайлагналын хувьд шинэ шатанд гарсан компани болж чадна гэдэгт итгэж байна. Мөн ийм байх замналыг сонгож байгаа нь маш чухал үйл явдал юм.

С.МЯГМАРСҮРЭН /ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ/: Компанийн хэрэгжүүлэхээр төвлөсөн төвлөгөөг дэмжиж байна. Бүх хувьцаа эзэмшигчдэд сайн нөлөөтэй гэж үзэж байна. Өнгөрсөн жил МХБ-д бүртгэлтэй гурилын үйлдвэрлэл эрхэлдэг "Хөвсгөл Алтандуулга" ХК гэж компани хувьцаагаа хувааж, нэмж хувьцаа гаргасан. Тэдний хөрөнгө босголт амжилттай болсон бөгөөд хөрөнгийн зах зээлийн хөгжилд зөв жишиг тогтоосон маш сайн жишээ болж чадсан. Одоо манай компани мөн адил замыг сонгож байгаа нь тун зөв юм. Бүх талаар дэмжиж байгаагаа илэрхийлье. Амжилт хүсье.

Б.ТҮВШИНЖАРГАЛ /ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ/: ХЭХ-н материалтай танилцлаа. Тодорхой зорилтууд тавьсан байгааг дэмжиж байна. Мөн өмнөх санал хэлсэн хувьцаа эзэмшигчийн жишээ болгож ярьсан Хөвсгөл Алтандуулга ХК-н нэмэлт хувьцаа гаргахын өмнөх болон дараах үр дүнг адилхан судалж үзсэн. Хувьцааны арилжаа нь өдөр бүр арилждаг, үнэлгээ нь өссөн нэмэгдсэн байна лээ. Иймд манай компани нь ч гэсэн ийнхүү зорилт тавиад ажиллаж байгааг дэмжиж байна.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Үйлдвэрийн танилцуулга 10 орчим минутын бичлэг бүгдээрэй үзье.

Бичлэг үзэв.

Нэмж асуулт байна уу.

За, асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал руу орёе.

Хуралд оролцогчид дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Б.ТҮВШИНТӨР /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/: Бүртгэлийн өдрийн байдлаарх "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд тус компанийн нэмж гаргаж буй 142,845,000 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар ТУЗ-өөс саналыг оруулж ирсэн. Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар уг асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Ер нь бол компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд нийт хувьцааны 90% төвлөрсөн байгаа. Ийм ч учраас шинэ

хөрөнгө оруулагчдад хувьцаагаа санал болгож төвлөрлийг бууруулах нь олон нийтийн компани байх, сайн засаглал бүрэлдэх үндсэн зарчимд нийцнэ гэж үзэж байна. Нэмж хувьцаа гаргасны дараа олон нийтийн хувь эзэмшил 27.1% хүрч нэмэгдэнэ гэж төсөөлж байгаа. Энэ хувь хэмжээ нь МХБ болон СЗХ-ны шаардлага болох 25%-н босгыг хангах юм. Та бүгд ХЭХ-н материалд тусгагдсан тогтоолын төслийг уншина уу.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар тогтоолд санал авах юм байна. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байвал асууна уу. Гүйцэтгэх захирал үндэслэлээ бол сая хэллээ.

Санал, асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа орьё.

Хуралд оролцогчид дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Б.ТҮВШИНТӨР /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/: Компанийн хувьцааг хувааж байгаатай холбоотойгоор компанийн дүрэмд зохих өөрчлөлтийг оруулах хэрэгтэй болсон. Энэ хүрээнд хийгдэх дүрмийн өөрчлөлтийг хурлын материалд тусгасан байна. Та бүгдэд уншиж, танилцуулья.

"Дархан Гурил Тэжээл" ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлтүүдийг доорх хүснэгтэд заалт бүрээр оруулав.

ОДООГИЙН ЗААЛТ	ӨӨРЧЛӨХ ЗААЛТ
3.7. Компани нь нэг бүр нь 100(нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 614,603 ширхэг (зургаан зуун арван дөрвөн мянга зургаан зуун гурван) ширхэг зарласан болон гаргасан хувьцаатай байна.	3.7 Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 757,448,000 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 614,603,000 ширхэг энгийн хувьцааг гаргасан болно.

Түрүүн хувьцаа хуваах төслийг танилцуулах үеээр би та бүгдэд өгсөн мэдээллийг давтан өгье. Тогтоолын төсөл төлөвлөх явцад хуулийн компаниас зөвлөгөө авахад, нэг асуудлаар давхардсан тогтоол төлөвлөсөн байна гэж зөвлөсөн болно. Иймд бид Хувьцаа хуваах төслийг батлах болон компанийн дүрэмд өөрчлөлт оруулах хоёр асуудлыг нэгтгэж, ХЭХ-с нэг тогтоолын төсөл гаргахаар төлөвлөсөн болно. Ийнхүү нэгтгэсэн тогтоол гарсанаар эцсийн үр дүнд өөрчлөлт орохгүй юм.

Та бүгдийн зүгээс уг асуудалтай холбоотой асуулт байна уу.

Асуулт гарсангүй

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байвал асууна уу.

Санал, асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа орьё.

Хуралд оролцогчид дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТАЛААР ГАРСАН ТУЗ-Н ШИЙДВЭРИЙГ ТАНИЛЦУУЛАХ

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Б.ТҮВШИНТӨР /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/: Компанийн ТУЗ-н 2019 оны 02 сарын 19-ны өдрийн хурлын 02 тоот тогтоолоор 2018 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэр гаргасан болно. Компани нь 2017-2018 онуудад улаанбуудай худалдан авах эргэлтийн хөрөнгийн дутагдалтай байсан бөгөөд үүнээс хамаарч түр зогсолттой байгаа тул ногдол ашиг тараах боломж бүрдэхгүй байгаа билээ. Та бүгдэд тараагдсан хурлын материалд уг тогтоолын хуулбар орсон байгаа. Цаашид үйл ажиллагаагаа эрчимчүүлж, ашигтай ажиллаж, улмаар хувьцаа эзэмшигчдэд тогтмол ногдол ашиг өгдөг компани болохын төлөө хичээн ажиллах болно.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байвал асууна уу.

Санал, асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа орьё.

Хуралд оролцогчид дэмжив.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Хурлын дэгийн дагуу нэгдсэн асуулт, хариултандаа орцгооё. Та бүгдийн зүгээс асуулт байна уу.

Асуулт байхгүй юу?

Асуулт гарсангүй.

За санал авах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө ХЭХ-с гарах тогтоолын төсөлд редакцийн завсарууд оруулах саналтай байна. Хэвлэлтэд бэлдэх явцад зарим нэг үг үсгийн алдаа болон, дугаарлалтын алдаа орсон харагдаж байна. Утга санааны өөрчлөлт бол огт оруулахгүй. Та бүгд хурлын материалд байгаа ХЭХ-с гарах тогтоолын төслүүдэд анхаарлаа хандуулна уу. Үг үсгийн алдааг залруулсан байдлаар нь тогтоолын төсөл бүрийг уншиж танилцуулья.

ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 дүгээр сарын 27

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 5.4.9 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс "2018 онд төлөвлөгөөний дагуу бүхий л боломжоороо ажилласан" гэсэн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

Хурлын Дарга

**ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 04 дүгээр сарын 27

№ 02

Улаанбаатар хот

***Хувьцаа хуваах төслийг баталж,
Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай***

Монгол улсын Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, 51.5, 51.6, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6, дахь заалт, "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн дүрмийн 5.4.1, 5.4.6 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа хуваах төслийг хавсралтаар баталсугай.
2. Компанийн 1 (Нэг) хувьцааг 1000 (Нэг мянган) ширхэг хувьцаанд хөрвүүлэх замаар хувааж, компани нийт 614,603,000 ширхэг гаргасан, энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
3. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 10 мөнгө байхаар тогтоосугай.
4. Хувьцаа хуваасантай холбогдуулан 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн "Дархан Гурил Тэжээл" хувьцаат компанийн дүрмийн 3.7 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3.7. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 757,448,000 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 614,603,000 ширхэг энгийн хувьцааг гаргасан болно.

5. Энэхүү тогтоолын 4-т заасан өөрчлөлтийг тусгасан "Дархан Гурил Тэжээл" хувьцаат компанийн дүрмийг хавсралтаар баталгаажуулсугай.
6. Компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд; мөнхүү өөрчлөлтийг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд; Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт тус тус бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Түвшинтер)-д үүрэг болгосугай.
7. Компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэгийн өөрчлөлтийг санхүүгийн тайланд зохих ёсоор тусгахыг Гүйцэтгэх захирал (Б.Түвшинтер), Ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхцэцэг) нарт үүрэг болгосугай.
8. Энэхүү тогтоолын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (дарга Ш.Энхтөр)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

**ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2019 оны 04 дүгээр сарын 27

№03

Улаанбаатар хот

***Хувьцаа нэмж гаргах төслийг баталж,
нэмж хувьцаа гаргах тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62 дугаар зүйлийн 62.1.1. дахь заалт, "Дархан Гурил Тэжээл" Хувьцаат компанийн дүрмийн 5.4.1, 5.4.3, 5.4.8, 5.4.13 дахь заалтыг удирдлага болгон 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1."Дархан Гурил Тэжээл" ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг босгох зорилгоор 142,845,000 ширхэг (хувьцаа хуваагдсаны дараах тооцооллоор) энгийн хувьцааг олон нийтэд санал болгон нэмж гаргасугай.

2. "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн хувьцаа нэмж гаргах төслийг хавсралтын дагуу баталсугай.

3. "Дархан Гурил Тэжээл" ХК -ийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй тул хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх шаардага үүсэхгүй болохыг дурдсугай.

4. Нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох үнэ, нэмж гаргах хувьцаатай холбоотой асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

5. "Дархан Гурил Тэжээл" ХК -ийн нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг СЗХ болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах, харилцах ажлыг шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Түвшинтөр/-д үүрэг болгосугай.

6. Нэмж гаргасан хувьцааг зохих журмын дагуу бүртгүүлэн олон нийтэд санал болгон амжилттай арилжсан тохиолдолд компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал товлон хуралдуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Энхтөр)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 дүгээр сарын 27

№ 04

Улаанбаатар хот

***Тэргүүн ээлжинд худалдан авах
эрхийг хэрэгжүүлэхгүй тухай***

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь заалт, "Дархан Гурил Тэжээл" Хувьцаат компанийн дүрмийн 5.4.8 дахь заалтыг удирдлага болгон 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүртгэлийн өдрийн байдлаарх "Дархан Гурил Тэжээл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд тус компанийн нэмж гаргаж буй 142,845,000 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Та бүгдэд тогтоолын төслүүдийг уншиж танилцуулж дууслаа. Одоо санал авах үйл ажиллагааг эхлүүлэе. Саналын хуудас бөглөх зөвлөмжийг Тооллогын комиссоос өгнө үү.

САНАЛ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Б.БАТБАЯР / ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА/: Та бүгдэд саналын хуудас тарааж өгсөн байгаа. Өөрийн овог, нэр, эзэмшиж буй хувьцааны тоо ширхэгийг бичнэ. Өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудлууд нь энгийн аргаар санал авах асуудлууд байгаа бөгөөд та бүхэн тухайн асуудал бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түтгэлзсэн гэсэн сонголтоос аль нэгийг сонгож, сонголтоо + тэмдэглээг ашиглан баталгаажуулна үү. Мөн саналын хуудасны доод хэсэгт байгаа гарын үсэг зурах хэсэгт гарын үсгээ зурна үү.

Түрүүн хувьцаа хуваах төслийг танилцуулах үеээр Б.Түвшинтөр захирал яагаад тав биш дөрвөн асуудлаар санал авч байгаа талаар тодорхой мэдээлэл өгсөн. Та бүгдийн зүгээс асууж тодруулах зүйл байна үү.

Саналын хуудсаа бөглөж дууссан бол тооллогын комисст өгнө үү.

Саналуудыг тоолж, дүнг нэгтгэж эхлэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:**Б.БАТБАЯР / ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА/:**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дараах асуудлуудаар ердийн аргаар санал өгөх байв.

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
2. Хувьцаа хуваах төслийг баталж, Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
3. Хувьцаа нэмж гаргах төслийг баталж, нэмж хувьцаа гаргах тухай
4. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй тухай

Тооллогын комисс нийт хувьцааны 75.25 % буюу 462,484 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүлээн авсан. Саналын хуудсыг тоолоход 6 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас 100% хүчинтэй байлаа.

Саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Хувьцаа эзэмшигчдээс ердийн аргаар өгөх нийт хүчинтэй саналын эрхийн тоо 462,484 байлаа.

1. Саналын хуудсаар "Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай" асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчид 100 % зөвшөөрсөн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
462,484	100	-	-	-	-

2. Саналын хуудсаар "Хувьцаа хуваах төслийг баталж, Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай" асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчид 100 % зөвшөөрсөн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
462,484	100	-	-	-	-

3. Саналын хуудсаар "Хувьцаа нэмж гаргах төслийг баталж, нэмж хувьцаа гаргах тухай " асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчид 100 % зөвшөөрсөн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
462,484	100	-	-	-	-

4. Саналын хуудсаар "Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй тухай" асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
462,484	100	-	-	-	-

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гарч буй тогтоол, шийдвэрийг тус тус уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга, Б.Батбаяр, Тооллогын комиссын гишүүд, Д.Энхболд, Б.Нямдэлгэр нар 02 тоот тооллогын комиссын тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулав.

Ш.ЭНХТӨР /ХУРЛЫН ДАРГА/: Өнөөдрийн хурлаар санал авсан 4 асуудлаар бүгд дэмжсэн байна. Одоо ХЭХ-н тогтоолыг хэрэгжүүлэх асуудалд удирдлагын баг бүрэн хүчээ дайчилж ажиллана гэдэгт итгэж байна. Мөн өнөөдрийн ХЭХ-н материалыг хуулийн хугацаанд багтааж СЗХ болон МХБ-д хүргээрэй.

Хуралдаа идэвхитэй оролцсон нийт хувьцаа эзэмшигчидээ баярлалаа. Өнөөдрийн хурал энд хүрээд өндөрлөснийг мэдэгдье.

Хурал өндөрлөв.

Хурлын тэмдэглэлд тооллогын комиссын тогтоол, саналын хуудас хавсаргав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал мөн өдрийн 14:00 цагт өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б. Тувшигмаргал

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДАРГА



/Ш.ЭНХТӨР/